

**САЛБАР ХУРАЛДААН 2 ОРЧУУЛГА**  
Хөтлөгч Ц.Онон (МУИС, Ази судлалын тэнхим)



**ОРЧУУЛГЫН СУРГАЛТ БА ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТ**

**Ц.Пүрэвсүрэн** доктор (Ph.D), проф.  
Монголын Үндэсний Их Сургууль

Япон хэлний симпозиум 2020

Орчуулгын сургалт ба япон хэлний сургалт

Ц.Пүрэвсүрэн  
доктор (Ph.D), проф.  
МУИС.ОУХС

•Орчуулгын хичээл бол япон хэлний сургалтын нэг хэсэг.

翻譯 通訳  
日本語教育

•Орчуулгын хичээл нь япон хэлний сургалттай салшгүй холбоотой.

語彙  
日本語教育  
文法  
意味  
言語習慣

**Монгол дахь орчуулгын сургалт** (бакалаврын түвшинд) :

- ❖ Монголд орчуулагч бэлтгэх ажил орос хэлний мэргэжилтэн бэлтгэх сургалтын туршлагад суурилсан.  
“Ерөнхий орчуулга” “Общий перевод” 「翻通訳の基礎」
- ❖ Монголд япон хэлээр бэлтгэн гаргасан мэргэжил :
  - Япон хэлний багш
  - Япон хэлний орчуулагч
  - Аялал жуулчлалын менежер
  - Япон хэлний багш орчуулагч
  - Япон судлаач
  - Олон улсын харилцааны мэргэжилтэн...



**Орчуулгын сургалтын агуулга :**

Орчуулга бол бодит сургалт.

- Орчуулгын онол (7 хоногт 1-2 лекц) 1-2кр
- Бичгийн орчуулга—Я-М,М-Я (7 хоногт 2 дадлага хичээл) 2-4кр
- Хэлмэрчлэхүй—Я-М,М-Я (7 хоногт 2 дадлага хичээл) 2-4кр
- Уран зохиолын орчуулга (сонгон) 1кр
- Албан бичгийн орчуулга (сонгон) 1кр
- Эрдэм шинжилгээний орчуулга (сонгон) 1кр

**Орчуулгын дадлага хичээл :**

• Орчуулгын эх хэл(source language)болон орчуулах хэлний(target language)бичвэр дэх тема-рема болох үйл явц (Theme\Rheme progression)、хураах(ellipses)、харьцаа заах холбоос(cohesion)、нэршүүлэх(nominalization)гм орчуулгын анализаар дамжуулан、япон-монгол хэлний үгийн сан-хэлзүйн нөөц(lexico-grammatical resources)-ийн хэрэглээнд илрэх нийтлэг болон ялгаатай талыг орчуулгын дадлага хичээлээр дамжуулан суралцдаг.

**Хичээлийн үйл явц :**

- SLT –ийг орчуулах
- Оюутны 「орчуулгын бүтээл」 -ийг анги дотор танилцуулж 「орчуулах явц」 дахь анзаарагдсан зүйл,мөн 「орчуулгын сонголт」 ын шалтгааныг тайлбарлуулах
- Сүүлд нь оюутны комментыг оролцуулан、багшийн орчуулсан хувилбарт анализ хийх
- Зарим тохиолдолд SLT баTLT параллель текст дээр орчуулгын анализ хийх


**Хичээлийн үйл явц :**



**Орчуулгын сургалтын тулгамдсан асуудал :**

❖Текстийн анализ :

Монгол – япон хэлний нийтлэг ба ялгаатай тал дээр суурилна. Текст анализын чадвар сул : 「эквивалент」 ийг олоход учрах саад



❖ Япон хэлний сургалттай холбоотой : Хэлний 4 чадвар

- Анхан шатны япон хэлний сургалт дахь орчуулж унших. Япон хэлний орчуулгын анхны суурь чадвар олгох асуудлыг харгалзсан үзэж хөтөлбөрийг шинэчилэх
- Синонимын хэрэглээ
- Хэлзүйн сургалтыг анхаарах —Н.Ө болон ХНӨ дэх холбоосууд

❖ Дунд сургуулийн эх хэлний сургалттай холбоотой :

- Орчуулгын хичээлээр сурах ёстой болж байгаа олон зүйлүүдийг дунд сургуульд сурсан байх ёстой.
- Унших чадвар
  - Ойлгох чадвар
  - Эх хэлээрээ бичих чадвар

❖ Орчуулга заах багш – Багшийн хомсдол

- Дараах чадвар шаардлагатай
- (a) Уран зохиолын багшийн хэмжээний унших чадвартай байх
- (b) Ойлгосноо утга зохиолын хэлний хэм хэмжээнд буулган бичих чадвар
- (c) Орчуулгын ажлыг бүхэлд нь ойлгодог байх. Эхнээс нь дуустал орчуулгын үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээ, үйл явцыг зүрх сэтгэлээрээ мэдэрч чаддаг байх

**Дүгнэлт**


- ❖ Орчуулгын сургалтыг хэлний чадвартай холбоотойгоор авч үзэх шаардлагатай.
- ❖ Даяаршлын эрин үед орчуулгын гүйцэтгэх үүрэг улам өсөн нэмэгдэж байна.
- ❖ Монгол-япон, япон- монгол орчуулгын судалгааг идэвхжүүлснээр орчуулгын сургалт сайжирна.
- ❖ Орчуулгын сургалтын япон хэлний сургалтын хавсрага байдлаар үзэж ирснийг эргэн харах нь зүйтэй.

第13日本語教育シンポジウム . 2020

翻訳教育と日本語の授業との連携

Ts. Purevsuren  
教授、Ph.D  
モンゴル民族大学・国際関係学部

• 翻訳教育は日本語教育の一部である。



• 翻訳教育と日本語教育は顕密な関係を持っている。





**モンゴルでの翻訳教育（学部レベル）：**

❖モンゴルでの翻通訳者養成はロシア語教育の経験に基づいた。

“Ерөнхий орчуулга” “Общий перевод” 「翻通訳の基礎」

❖モンゴルでの日本語教育：

- 日本語教師養成
- 日本語翻通訳者
- 観光マネージャー
- 日本語教師・翻通訳
- 日本研究者
- 国際関係専門家



**翻訳教育の内容：**

翻訳は実学なのである。

- 翻訳論（週一回、2週一回の講義）1-2単位
- 翻訳一日蒙・蒙日（週2回の実践）2-4単位
- 通訳一日蒙・蒙日（週2回の実践）2-4単位
- 小説翻訳（専攻）1単位
- 公式文章訳（専攻）1単位
- 学術文章訳（専攻）1単位


**翻訳実践の構成：**

- 起点言語(source language)および目標言語(target language)のテキストにおける主題一題述の展開(Theme\Rheme progression)、省略(ellipses)、結束性(cohesion)、名詞化(nominalization)などの分析を通して、日本語とモンゴル語における語彙一文法起源(lexico-grammatical resources)の具現のしかたの類似性や差異を翻訳演習で学ぶ。

**授業の流れ：**

- SLT を演習課題として翻訳
- 各自の「作品」をクラスで共有しながら翻訳の「過程」で気が付いたところと、または「選択」をした理由をコメント
- 最後に学生のコメントに関連つけて、教師サイドからの分析
- 場合によってSLTとTLTの平行なテキストを配布して分析する

**授業の流れ：**



### 翻訳教育の問題点

#### ◆テキスト分析：

モンゴル語と日本語の言語学的共通点と相違点から分析する。  
テキスト分析の視点が弱い ・ 「等価」を阻害しているものがある

語彙－文法  
レベル

背景知識

文化のコンテキスト  
状況のコンテキスト

#### ◆日本語教育との関係：言語4技能

- 初級日本語教育としての日本語分文訳読の上に、翻訳があるのである。翻訳の授業を受けるに足る日本語文読解基礎力をつけるカリキュラムの作成を強く望みたい
- 類義語の使い分け
- 文法教育の重視が望まれる  
－ 重文・複文レベルの接続語・接続詞の使い分け

#### ◆学校の母語教育との関係：

翻訳教育で教えるべき点の大部分は、本来なら学校教育で教えるべき点なのだ。

- 読む力
- 理解する力
- 母語で書く力

#### ◆教える教師（教師不足）

• 翻訳を教えるには次のような要件が必要だ。

- (a) 日本文学教員程度の読解力があること
- (b) 理解をきちんとした母語に置き換える文章力があること
- (c) 翻訳業界全体を俯瞰できること。つまり商品としての翻訳全般を知り、そのニーズとシーズを心得ていることが必要だ。

#### まとめ

- ◆ 翻訳教育を語学力との関係から考察することが必要である。
- ◆ 国際化が進んでいる現在、翻通訳の役割が一層重要とされている。
- ◆ 日蒙・蒙日翻訳の比較研究を進むことによって翻訳教育も向上できる。
- ◆ 翻訳教育が日本語教育の「付き添える物」であったことを見直す必要がある。

## АСУУЛТ, ХАРИУЛТ

**АСУУЛТ 1:** Сайн байна уу? МУИС-ийн багш Ц.Дэлгэрэхцэцэг байна. Пүрэвсүрэн багшаас санал асуумаар байна. Ерөнхийдөө манай их дээд сургуулиуд хангалттай өндөр түвшний хэлмэрчлэхүй болон бичгийн орчуулга хийж чаддаг мэргэжилтэн бэлдэж чадахгүй байна гэдэг дүгнэлтэд хүрээд байна тийм үү? Ер нь бол хөтөлбөрийн агуулга бага. Хэлний үндсэн мэдлэгийг эзэмшүүлэх гэсээр байгаад юун тэр өндөр түвшний мэдлэг, түүнд хүрч амжилгүй төгсчихдөг. Түүнээс гадна бодитоор орчуулгын чадвар суулгадаг хичээлийн тоо цөөхөн, багтаамж нь цөөхөн, кредит цаг нь бага байдаг. Манайх ч бас ялгаагүй тийм байгаа. Тийм болохоор цаашид үүнээс гарах арга зам ч гэдэг юм уу, одоогийн байдлаас сайжруулах, ер нь яамаар байна вэ? Багш та юу гэж бодож байна вэ? Өөрийнхөө туршлага дээр тулгуурлаад, өөрөөр хэлбэл Японд ч гэсэн үүнийг их дээд сургууль хангалттай хийж чаддаггүй гэж Шинзаки багш хэлсэн шүү дээ. Тусгай тодорхой тогтолцоотойгоор, тодорхой байгууллагууд нь бэлдээд явчихдаг гэсэн. Манайд тийм боломж байна уу? Тийм юм хийвэл яаж хийх вэ гэдэг ч юм уу? Тэр тал дээр танд бодол байвал бид нартай хуваалцаач. Өөрөөр хэлбэл тодорхой түвшинд хүрсэн хүмүүст техник юмыг нь сайжруулж өгдөг сургалт, дамжаа гэх нь бас хаашаа юм. Тийм тодорхой институт бий болгоод тэгвэл цаашдаа сайжрах боломж байна уу? Эсвэл яаж ийгээд их дээд сургууль хөтөлбөр дотроо багтаагаад, аль нэг хичээл дотроо агуулаад



өргөжүүлэхийн төлөө явах ёстой юм уу? Ер нь явал зохистой юм бэ? Ер нь тийм юм хийх ёстой юм бол ямар байгууллага энийг хийх ёстой вэ? Мэргэжлийн, манайх шиг холбоонууд хийгээд явах ёстой юм уу? Болох уу, болохгүй юм уу? Ингэвэл бизнес болчих юм болов уу, Монголд. Энэ тал дээр та саналаа хуваалцаач.

**ХАРИУЛТ 1:** Манайд бол орчуулга гэдэгт ханддаг хандлага, нийгмийн сэтгэл зүйд жаахан өөрчлөлт хиймээр юм шиг байгаа юм. Ярихад амархан л даа, хийхэд хэцүү. Олон улсын практикаар мэргэжлийн орчуулагч бэлдэнэ гэвэл 4 жилээ байг. Монгол хүний хэлний чадвар гэдэг юм байна шүү дээ. Тухайлбал, айдас бага байдаг, олон улсын эрдэмтдийн хийсэн судалгаа зэргээс харахад гадаад хэл сурахад монгол хүнд тулгардаг бэрхшээлүүд бага, сэтгэл зүйн тэсвэр, тэвчээр гээд монгол хүнд олон давуу тал байгаа. Тэгэхээр би боддог юм. Орчуулгын 2 жилийн түргэвчилсэн курс, тэгэхдээ байгууллагын захиалгаар хийвэл зүгээр байх. Одоо бол боловсрол чинь үйлдвэрлэл болчихсон учраас эрэлт нийлүүлэлт гэдэг юмыг харгалзан үзэх юм бол байгууллагын захиалгаар зүгээр байх. Массын сургалт хэцүү байх. Ер нь орчуулга гэдэг зүйлд ханддаг хандлагыг өөрчилье гэвэл япон хэлний сургалтыг агуулгын интеграц хийх боломж байна уу үгүй юу гэдгийг хармаар л юм шиг байгаа юм. Манайд чинь ганц мэргэжлээр бүтэн 4 жил сураад, төгсөөд гараад зах зээл гэдэг нь юу байна. Тэгэхээр магадгүй эрт хэлж байсан, орчуулагч гаргаад хичээлийн агуулгынх нь интеграцыг хиймээр. Тэгээд манайхыг төгссөн хүүхдүүдээс санал их тавьдаг. Багш аа, орчуулгын курс явуулаач гээд. Гараад төгсчихсөн улсуудад техникийн чиглэлээр, техникийн компанид ажилладаг тэр чиглэлээр орчуулга хийдэг болмоор байна гэдэг ч юм уу? Ийм чиглэлийн сургалт, хөтөлбөрүүд боловсруулаад тэгээд ганцаарчилсан, эсвэл групп болгож сургалт явуулна уу гэхээс массын сургалт гэвэл манайд зах зээл бага учраас үр дүн муутай байх. Нийгмийн эрэлт юу байна, япон хэлний сургалт дотор орчуулгын сургалтын агуулгыг интеграцчилж өгөөд, энэ хоёрыг жаахан ойртуулах боломж юу байна, нөгөө талаас эрэлтэд нийцсэн ийм богино хэмжээний сургалтуудыг интенсив агуулгаар явуулах ийм боломж юу байна, тэгээд компаниудтай гэрээ байгуулаад явуулахад боломжийн юм уу гэж бодож байна.

**АСУУЛТ 2:** Би япон хэлний орчуулга ямар үнэлгээтэй байдгийг мэдэхгүй байна. Англи хэл бол синхрон орчуулга хийдэг бол цагийн 150 доллар, дагаж орчуулах бол цагийн доод тал нь 100 доллар байдаг. Ингээд цалинг нь өндөр тогтоочихсон болохоор бичгийн орчуулга гэрээнээсээ хамаараад хуудас нь 50 доллараас эхэлнэ. Цалин өндөр учраас тэр орчуулгыг хийх гэж их орж ирж байна л даа. Нэг шалгаруулалтад 300-400 орчим хүн орж ирдэг. Түүн дотроос үнэхээр яг тэр салбартаа, хэдэн жил орчуулга хийсэн орчуулагч гэхээр 4 жил сураад, дээд сургууль төгсөөд ч юм уу, гарч ирээд 3 жил ажиллаад болчихдог тийм зүйл биш шүү дээ, дор хаяж тэр салбартаа мэргэжлээрээ 10-аад жил ажиллачихсан, нэлээн хэдэн жилийн орчуулгын туршлагатай байж байж л тэрийг мэргэжлийн түвшинд орчуулж гарч ирж байгаа шүү дээ. Тийм орчуулагч нарыг шалгаруулаад, олон улсын байгууллагуудад өөрсдийнхөө салбар дээр орчуулдаг мэргэшсэн орчуулагч нар бий болчихоод байгаа. Яг тийм орчуулагч нар япон хэлний салбарт байгаа юу? Хэрвээ тийм орчуулагч нар байгаа бол тийм орчуулагч нараар таны яриад байгаа богино хугацааны сургалтыг байгууллагууд дээр хийх боломж хэр байна вэ? Хоёрдугаарт орчуулагчдын цалин хөлс өсөж байж, хүсэж зорьж очих хүмүүс нэмэгдэх учраас энэ боломж ямар байна вэ?



**ХАРИУЛТ 2:** Орчуулгын практикт бол япон хэл, хятад хэл бол хүнд хэлний ангилалд багтдаг. Орчуулгыг олон улсын жишгээр үнэлдэг түвшинд бол япон хэл бол орчуулгын хөлс өндөр шүү дээ. Жишээлбэл, би өөр дээрээ л хэлье. Элчин сайдын яаманд орчуулга хийхэд цаг нь 100 доллар гэдэг ч юм уу. Гадаад харилцааны яам дээр олон улсын хамтарсан эдийн засгийн форум дээр бол зөвхөн хяналтад суухад цагийн 100 доллар гээд ийм үнэлгээнүүд байдаг. Сүүлийн үед бол ерөнхийдөө япон хэлний орчуулгын үнэлгээ өсөж байгаа. Цаашдаа ч өсөх байх, яагаад гэвэл орчуулгын чанар, тавигддаг стандарт, орчуулгын хэрэгцээний түвшин өндөр болж байгаа. Түүнийг эцсийн эцэст орчуулагч нар өөрсдөө мэднэ. Япон хэлний орчуулагчдын холбоо, нэгдсэн байгууллагыг бол би сайн мэдэхгүй байна. Тэр орчуулгын үнэлгээг өндөржүүлэх гэдэг үнэн. Нэг талдаа бол хариуцлагажуулах, нийгмийн сэтгэл зүйд хүртэл өөрөөр нөлөөлнө. Манайд бол одоо хэлний түвшин тогтоох шалгалтууд л авч байгаа болохоос биш орчуулагчийн түвшин тогтоох шалгалт гэдэг зүйл ерөөсөө орж ирээгүй байх. Олон улсын жишгээр, Японд бол орчуулагчийн түвшин тогтоох шалгалтууд байна. Тэр нь бүр мэргэжлийн орчуулга, хуулийн орчуулга гэж задраад зөвхөн IT чиглэлээр, зөвхөн хуулиар, зөвхөн анагаахаар “шикакү” өгдөг. Шикакү өгөөд тэр нь бүртгэлтэй байж байдаг. Тийм төрлийн орчуулга дээр орчуулагчаа дуудаад, дуудаад орчуулга хийлгэдэг ийм зүйл Японд бол байдаг. Манайд бол орчуулагч гэдэг энэ мэргэжил нь сүүлийн үед бэлдэхээ больчихлоо л доо. Орчуулагч бэлдэж байгаа сургууль бараг байхгүй. Хэл бол мэргэжил биш гэдэг ийм сонин ойлголт яваад байна шүү дээ. Орчуулагч бэлтгэдэг сургуулиуд цөөрөөд орчуулагчдад ханддаг хандлага бол шал өөр болчихсон. Гэхдээ орчуулгын хэрэгцээ нь өсөөд байдаг. Үүнийгээ дагаад багш нарын холбооны шугамаар тэртэй тэргүй хөтөлбөрийн нэг хэсэг яалт ч байхгүй мөн. Магадгүй бид ойрын ирээдүйд орчуулагчийн түвшин тогтоодог, албан ёсны шалгалт биш гэхэд өөрсдийн стандарт тогтоодог Японд баримталдаг ерөнхий шалгууруудыг авч үзэх нь зөв. Тэгэхээр манай орчуулагч нарын өнөөдрийн түвшин ямар байна, цаашид яамаар байна гэдэг дүр, хар зураг гараад үүндээ сууриалаад олон улсын түвшин тогтоодог шалгалтуудтай холбогдоод түүнээс зөвшөөрөл аваад шалгалтыг нь аваад, түвшинг тогтоодог тийм зүйл бий болно гэхэд үгүй гэх газар байхгүй. Гэхдээ олон улсын даяаршсан түгээмэл хэл гээд англи хэлтэй зэрэгцүүлэхэд хамаарагдах хүмүүс нь хэр бол тэрийг бас судалгаа хийх хэрэгтэй. Орчуулагчийн түвшин тогтоох гэдэг зүйл хэрэгтэй. Түүгээрээ орчуулагчийг үнэлнэ шүү дээ.